



МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

2021

ЖИЛИЙН
ТАЙЛАН



АГУУЛГА

- ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНАА 4
- ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАГНАЛ /МАЯГТ 1/
- САНГИЙН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 12
- САНГИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТҮҮНД ХИЙГДСЭН ХАРААТ БУС АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ДҮГНЭЛТ 17
- САНГИЙН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТ 20
- МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИЙН ИТГЭМЖЛЭН УДИРДАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИЛИЙН ТАЙЛАН 22
- КАСТОДИАНД ХӨРӨНГӨ ХАДГАЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИЛИЙН ТАЙЛАН 23

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНАА



G. Ganzorig

Сангийн менежер
Г.Ганзориг

Хөрөнгө оруулагч та бид хамтдаа Монголын хамгийн том хөрөнгө оруулалтын санг байгуулж чадсан том үйл хэргийн эхлэл тавигдсан жил болж өнгөрлөө.

Системийн банкнууд IPO-н нүсэр ажлын бэлтгэлээ базаасаар сүүлийн их сунгаандаа орох л үлдээд байна. Өнгөрсөн оны 12 сард Банкны эхний IPO-г Богд банк хийж, 32 тэрбум төгрөг татан төвлөрүүлснээр олон нийтэд нээлттэй банк боллоо. Энэ оны 2 сард Голомт банк нээлттэй хувьцаат компани болох зөвшөөрлөө Монголбанкнаас аваад байна. Удахгүй Хаан, Худалдаа хөгжил, Хас, Төрийн банкны зөвшөөрөл гарах л үлдлээ.

Системийн банкнуудын IPO хийх ажил хүлээгдэж байх хугацаанд бид банкны үнэлгээгээ эцэслэн гаргаж, банкны удирдлагуудтай холбогдох уулзалтыг тогтмол хийн хэлэлцээрийн түвшинд ажиллаж байна. Мандал Ирээдүйн Өсөлт сангийн хөрөнгө оруулагч таныг ирээдүйн өндөр өсөлттэй банкны эзэн болгож, оновчтой, эрсдэлгүй, өгөөжтэй хөрөнгө оруулалт хийх нь бидний тэргүүн зорилго болно.

Санхүүгийн зах зээлийн нэгэн дүрэм бол “Мөнгө унтах ёсгүй”. Одоогоор Мандал Ирээдүйн Өсөлт сангийн хөрөнгө нь мөнгөний захын хэрэгсэл болон хөрөнгийн захын нээлттэй хэрэгслүүдэд тус тус байршиж, цэвэр хөрөнгийн үнэ цэн өссөөр байна.

Та бидний хувьд 2022 он эрсдэлгүй, өгөөжтэй сайхан жил болно гэдэгт итгэлтэй байна.

Холыг харж, ХОС-г сонгосон хөрөнгө оруулагч танд баярлалаа.

ЭДИЙН ЗАСАГ: ХАДГАЛАМЖИЙН ӨГӨӨЖӨӨС ӨНДӨР ИНФЛЯЦ

2021 оны жилийн эцэст Монгол Улсын инфляцын түвшин 13.4%-д хүрэв. Энэхүү өндөр инфляц нь эдийн засгийн өсөлтөөс бус Ковид-19 цар тахлаас шалтгаалав. Тухайлбал БНХАУ ачаа таваарын хөдөлгөөнийг зогсоож, хилээ хааснаар Монгол Улс нийлүүлэлтийн хомстолд орсон төдийгүй шатахууны үнэ нэмэгдсэн. Хадгаламжийн 7%-с давсан энэхүү инфляц нь мөнгөний үнэ цэнийг алдагдуулж байгаа тул хөрөнгөө хамгаалж, оновчтой хөрөнгө оруулалт хийх нь маш чухал болов.

САНХҮҮГИЙН САЛБАР: БАНКНЫ САЛБАРЫН ШИНЭТГЭЛ

2021 оны 1 сарын 29-нд батлагдсан “Банкны тухай хууль”-ийн нэмэлт өөрчлөлтөөр Монголын банкнуудыг олон нийтэд нээлттэй хувьцаат компани болгох, эзэмшлийн төвлөрлийг бууруулахад чиглэсэн зүйл заалтууд тусгагдсан нь санхүүгийн салбарын онцлох үйл явдал байв. Монголын топ аж ахуй нэгжүүд болох банкнууд хөрөнгийн зах дээр арилжаалагдаж эхэлснээр уг зах зээлийн хөгжлийн хурдасгуур болж олон улсын жишигт нэг шатаар дөхүүлж буй. Мөн банкны салбарын хөрөнгө нь Монгол Улсын ДНБ-тэй тэнцдэг ба ийнхүү хамгийн том, ашигтай, тогтвортой салбарын тоглогчид олон нийтэд нээлттэй болсноор макро эдийн засгийн урсгалыг дэмжиж, баялгийн хэт төвлөрлийг сааруулах чухал нөлөөтэй юм.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ: АНХНЫ 50 ТЭРБУМЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 8 сарын 18-ны өдрийн 328 тоот тогтоолоор Монголын хамгийн том хөрөнгө оруулалтын сан болох Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын ХОС үүсгэн байгуулагдав. Анхдагч зах зээлийн захиалга төлөвлөгөөт хугацаанаас өмнө давж, 50 тэрбум төгрөгийн амжилттай татан төвлөрүүлснээр хоёрдогч зах зээлд 2021 оны 8 сарын 20-ны өдрөөс эхлэн MFG нэршил бүхий сангийн нэгж эрх арилжаалагдаж эхэлсэн. Энэ нь Монголын хөрөнгийн зах зээлийг идэвхжүүлэх ач холбогдол бүхий тэмдэглэлт үйл болов.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2021 ОНЫ 06 ДУГААР САРЫН 11-НИЙ ӨДРИЙН 225 ДУГААР ТОГТООЛООР БАТАЛСАН “ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛИЙН ЖУРАМ”-ЫН 4 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/

Тайлагналын хугацаа	2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	“Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС” ХХК, 9011827609, 6702988, MFG, 75759911
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК
Бизнесийн үйл ажиллагааны салбар:	Санхүү
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	“Онч Аудит” ХХК
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	50,000,000
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр:	Дашцэрэн овогтой Баатаржав, Ерөнхий захирал
1.1 Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт	Хуудас 15
1.2 Аудитын тодорхойлох	Хуудас 15
2 Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл	Хуудас 18
2.1 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбар эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	Хуудас 14
2.2 Хөрвөх чадвар болон боломжийн үзүүлэлт	

<p>2.3 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл</p>	<p>Банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлт 2022.06.30-с өмнө системийн нөлөө бүхий банкууд IPO хийх үүрэг хүлээсэн. Тиймээс сан нь тус IPO зарлагдах хүртэл богино хугацаатай хөрвөх чадвар өндөр нээлттэй санхүүгийн хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийхэд анхаарч ажиллав. 2021 оны тайлант хугацаанд багцын 4 хувийг эрсдэлтэй хөрөнгө буюу хувьцаанд байршуулсан бол үлдсэн хувийг эрсдэл бага, тогтмол өгөөж бүхий бонд, мөнгөний захын хэрэгсэлд байршуулсан. Компанийн хувьцааны багцын хувьд санхүүгийн секторын, худалдаа, үйлчилгээний секторын, хүнсний үйлдвэрлэлийн секторын тус тус нэг компанийн хувьцаанаас бүрдсэн байна</p>
<p>2.4 Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/</p>	<p>Санхүүгийн байдлын тайлангаас гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй</p>
<p>2.5 Тайлант хугацаанд авсан зээлийн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл</p>	<p>2021 онд авсан зээл байхгүй.</p>
<p>3 Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</p>	
<p>4 Цалин урамшууллын мэдээлэл</p>	<p>Сан нь “Мандал ассет менежмент ҮЦК” ХХК-тэй байгуулсан хөрөнгө оруулалтын менежментийн гэрээний дагуу жилийн үйлчилгээний шимтгэл болох сангийн нийт цэвэр активын 1 хувь болон үйл ажиллагааны гүйцэтгэлийг урамшуулах болох сангийн өмнөх жилийн нийт ашгийн арван 10 хувьтай тэнцүү шимтгэл төлсөн.</p>
<p>5 Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</p>	<p>Өлзийбаяр Ганзориг-ТУЗ-ийн дарга</p>
<p>6 Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл</p>	<p>Хуудас 12</p>
<p>7 Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/</p>	<p>Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид өөрчлөлт ороогүй. 2022 оны 04 сарын 04-ний өдрийн байдлаарх нөлөө бүхий хувьцаа эзэмшигч “Мандал ассет менежмент ҮЦК” ХХК- 5 хувь</p>

8	<p>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл</p>	Хуудас 10
9	Ногдол ашгийн мэдээлэл	<p>Сангийн 2022 оны 2 сарын 16-ны өдрийн 22/001 тоот Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тогтоолоор “Мандал Ирээдүй Өсөлт” хамтын ХОС нь Сангийн хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт заасны дагуу эдийн засгийн өсөлтийг хангах зорилгоор 2021 оны цэвэр ашгаас ХОС-ийн нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.</p>
10	<p>Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл</p>	<p>“Мандал ирээдүйн өсөлт хамтын ХОС” ХХК-ийн 7000 гаруй нэгж эрх эзэмшигчдийн хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх зорилгоор “Үнэт цаасны зах зээлийн ойлгох нь” сэдэвт онлайн сургалтыг зохион байгуулж, тус сургалтын агуулгыг бататгах зорилгоор сургалтанд хамрагдсан хөрөнгө оруулагч бүрт “Санхүүгийн философи” номыг бэлэглэсэн.</p> <p>“Мандал ассет менежмент ҮЦК” ХХК-ийн фэйсбүүк хуудсаар дамжуулан хөрөнгийн зах зээлийн мэдээлэл бүхий контентийг тогтмол боловсруулан хүргэж байна. Мөн “Эдийн засгийн сэтгүүлчдийн клуб”-ийн сэтгүүлчдэд хөрөнгийн зах зээл, макро эдийн засгийн мэдээлэл олгох сургалтыг улирал тутамд зохион байгуулж байна. “Оюу Толгой” ХХК, “Мон логистикс” ХХК гэх зэрэг томоохон аж ахуйн нэгжүүдийн албан хаагч, ажилчдад хөрөнгийн зах зээлд мэдлэг олгох сургалтыг тогтмол зохион байгуулж байна.</p>

САНГИЙН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Сангийн танилцуулга

Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын ХОС нь эрсдэлийн удирдлагын нэгдсэн тогтолцоог хэрэгжүүлэх замаар нийтээс татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг өөрийн бодлогын баримт бичиг болон хууль тогтоомжийн хүрээнд мэргэжлийн түвшинд үрашигтай хөрөнгө оруулалт хийх замаар үнэт цаасны зах зээлээс олсон өгөөжийг хөрөнгө оруулагчдадаа хүртээх зорилго бүхий мэргэжлийн хөрөнгө оруулалтын хуулийн этгээд юм.

Сангийн нэр	“Мандал Ирээдүйн Өсөлт” Хамтын хөрөнгө оруулалтын сан
Сангийн хэлбэр	Хамтын
Сангийн төрөл	Хаалттай
Сангийн үйл ажиллагаа явуулах хугацаа	10 жил
Татан төвлөрүүлсэн хөрөнгө	50 тэрбум төгрөг
Хөрөнгө итгэмжлэн удирдах компани	“Мандал Ассет Менежмент ҮЦК” ХХК
Хөрөнгө итгэмжлэн хадгалах	“Голомт Банк” ХХК – Кастодиан банкны хэлтэс
Холбоо барих хаяг	Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо Жамьян-Гүний гудамж, Меру тауэр-602 тоот Утасны дугаар: +976-75759911 Имэйл хаяг: support@mandalasset.mn

Сангийн зорилго

2021 оны 01 сарын 29-нд батлагдсан “Банкны тухай хууль”-н нэмэлт өөрчлөлтөд Монголын системийн нөлөө бүхий таван банк нь олон нийтэд нээлттэй хувьцаат компани болох тухай тусгагдсан. Үүний хүрээнд Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС нь “Олны Хүч Оломгүй Далай” уриатайгаар хөрөнгө оруулагчдыг нэгтгэсэн юм.

Сан нь мэргэжлийн судалгаа шинжилгээ болон эрсдэлийн менежментэд суурилан сангийн хөрөнгө оруулагчийг банкны "эзэн" болох шинэ түүхийн гүүр болж ажиллахаар зорьж байна.

Хөрөнгө оруулалтын бодлого

Сангийн хөрөнгө оруулалтын стратеги нь “income investing” буюу “тогтмол орлого” болон “growth investing” буюу “хөрөнгийг өсгөх” гэсэн хосолмол аргад суурилдаг. “Income investing” стратегийн хүрээнд хөрвөх чадвар сайтай үнэт цаасыг сонгон авч сангийн хөрвөх чадварыг хангадаг. “Growth investing” стратегийн хүрээнд өндөр өгөөжтэй байх үнэт цаасыг сонгон авч сангийн өсөлтийг хангадаг.

Сан нь зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан эрсдэлийн зохих түвшинд, хамгийн өндөр өгөөж олох байдлаар багцыг бүрдүүлдэг ба хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгийн хүрээнд ажиллана. Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгийн дагуу багцын 70%-д банкны хувьцаанд хөрөнгө оруулах боловч банкны IPO хийгдэх хугацаа хойшлогдсон тул одоогоор хөрөнгө оруулалтын багц нь томоохон нээлттэй компаниудын хувьцаа болон тогтмол орлоготой үнэт цааснаас бүрдэж байна.

Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл

Хөрөнгө оруулалтын сангийн багцын гол бүрэлдэхүүн болох банкуудын IPO хараахан эхлээгүй тул Мандал Ассет Менежментийн зүгээс сангийн хөрөнгийг компанийн хувьцаа, өрийн хэрэгсэл болон мөнгөний захын хэрэгсэлд байршуулсан.

2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар нийт 1 тэрбум төгрөгийн ашигтай (татвар төлсний дараа) ажиллаж, цэвэр хөрөнгийн үнэлгээ 51 тэрбум төгрөгт хүрлээ.

Сангийн хөрөнгийн бүтэц

Банкны тухай хуулийн дагуу 2022.06.30-с өмнө системийн нөлөө бүхий банкууд IPO хийх үүрэг хүлээсэн. Тиймээс сан нь тус IPO зарлагдах хүртэл богино хугацаатай хөрвөх чадвар өндөр нээлттэй санхүүгийн хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийхэд анхаарч ажиллав.

2021 оны тайлант хугацаанд багцын 4 хувийг эрсдэлтэй хөрөнгө буюу хувьцаанд байршуулсан бол үлдсэн хувийг эрсдэл бага, тогтмол өгөөж бүхий бонд, мөнгөний захын хэрэгсэлд байршуулсан.

Компанийн хувьцааны багцын хувьд санхүүгийн секторын, худалдаа, үйлчилгээний секторын, хүнсний үйлдвэрлэлийн секторын тус тус нэг компанийн хувьцаанаас бүрдсэн байна.

График 1: Сангийн хөрөнгийн бүтэц | хувиар




График 2: Хөрөнгө оруулалтын багцийн ангилал | хувь /2021/





График 3: Хувьцааны багц сектороор | хувь /2021/



Сангийн зардал

График 4: Сангийн зардлын бүтэц | сая.төгрөг



Менежментийн үйлчилгээний зардал

2021 оны 06-р сарын 15-ны өдөр Мандал Ассет Менежмент ҮЦК ХХК нь Сантай менежментийн үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулснаар хөрөнгө оруулалтын сангийн менежерээр томилогдож хөрөнгийг итгэмжлэн удирдаж эхэлсэн. ХОМК-ийн менежментийн үйлчилгээний жилийн шимтгэл нь сангийн нийт цэвэр хөрөнгийн 1%-р тооцогддог бөгөөд тус дүнг сар бүр тэнцүү хуваан төлдөг. Мөн өмнөх жилийн нийт ашгийн арван хувийг ХОМК-д урамшуулал болгон жилд нэг удаа төлдөг.

Хөрөнгийн Биржийн үйлчилгээний шимтгэл

МХБ-н жилийн үйлчилгээний хөлс нь сангийн цэвэр хөрөнгийн дүнгийн 0.1%-р тооцогддог бөгөөд жилд нэг удаа төлдөг. 2021 онд нийт үйлчилгээний шимтгэл нь 50.0 сая.төгрөг байна.

Кастодиан үйлчилгээний шимтгэл

Сангийн Кастодиан банкны үйлчилгээг Голомт банк гэрээний дагуу үзүүлдэг. 2021 онд нийт кастодианы үйлчилгээний шимтгэл нь 27.6 сая.төгрөг байна.

Ногдол ашиг

Сангийн үндсэн зорилго нь системийн нөлөө бүхий банкны хувьцаанд хөрөнгө оруулах болно. Банкны салбарын IPO нь 2022 оны эхний хагаст хийгдэх хүлээлттэй байгаа бөгөөд сан нь цаашдын хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх үүднээс нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

Эрсдэлийн удирдлага

Сан нь хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх тул нийгэм эдийн засаг, санхүү болон үйл ажиллагааны эрсдэлүүдийг удирдах шаардлага тулгарна. Тиймээс компанийн хэмжээнд эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрдүүлдэг. Тухайлбал ажилтан, хэлтэс болон сангийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг тогтмол тодорхойлох, үнэлэх, бууруулах нь эрсдэлийг оновчтой удирдах гол аргачлалын нэг юм. Эрсдэлийг удирдах доорх бүтцээр ХОМК нь сангийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбоотой бүхий л нөхцөл байдлыг үнэлж дүгнэдэг. Үйл ажиллагааны бүх түвшинд эрсдэлийн удирдлагын талаарх ойлголтыг нэвтрүүлэхийн сацуу ажилтан бүр энэ талын мэдлэгээ тогтмол дээшлүүлж ажиллахыг эрхэмлэдэг. Эрсдэлийн бодлогын хүрээнд дараах эрсдэлүүдийг түлхүүр болгон тодорхойлж, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж байна.

Хөрөнгө оруулалтын эрсдэл

Хөрөнгө оруулалтын эрсдэлийн хүрээнд багцын эрсдэлийг тооцож, тараан байршуулалт хийдэг. Хөрөнгө оруулалтын судалгаанд эрсдэлийн үнэлгээг заавал тооцдог ба эрсдэлийн удирдлагын олон жилийн туршлагатай баг хамт олон хөрөнгө оруулалтын шийдвэрийг гаргадаг.

- Хүүгийн түвшний эрсдэл:
Зах зээл дэх хүүгийн түвшин өөрчлөгдөх нь Сангийн мөнгөн хөрөнгийн хадгаламжийн өгөөжийн түвшинд нөлөөлнө. Иймд хүүгийн түвшний өөрчлөлт таамаглалыг улирал бүр шинэчилж, тогтвортой үйл ажиллагаатай, эрсдэл даах чадвар өндөр банкыг харилцагчаар сонгож ажиллана.
- Инфляцийн эрсдэл:
Сангийн хөрөнгө болон хөрөнгө оруулалтаас олох өгөөж нь ирээдүйн инфляцийн түвшин, мөнгөний үнэ цэнийн утгаас хамааран бодит утгаараа төлөвлөсөн хэмжээнээс бага байх эрсдэл бий. Инфляцийн өсөлт нь эдийн засгийн бусад хүчин зүйлст нөлөөлөх ба үнэт цаасны бодит үнэ цэнд нөлөөлнө. Сан нь инфляци, эдийн засгийн загварын таамаглал ашиглан ирээдүйн инфляцийн түвшинг тооцон ажиллана.
- Валютын ханшийн эрсдэл:
Ханшийн хэлбэлзэл нь зах зээлд тодорхой бус байдлыг нэмэгдүүлж эдийн засгийн үйл хөдлөлийн зардлыг ихэсгэдэг. Иймд ханшийн таамаглал эрсдэлийг тооцон ажиллана.

Үйл ажиллагааны эрсдэл

Сан үйл ажиллагаа явуулахад хүний нөөц, ашиглаж буй систем дотоод дүрэм журам болон зах зээлээс нөлөөлж болохуйц үйл ажиллагаатай холбоотой эрсдэлүүд хамаарна. Тухайлбал хүнээс хамаарах үйл ажиллагааны алдаа, технологийн доголдол болон хууль эрх зүйтэй холбоотой эрсдэлүүд багтдаг. ХОМК-ийн хүний нөөцийн эргэц бага, олон жилийн туршлагатай мэргэжилтнээс бүрдэж байгаа нь үйл ажиллагааны эрсдэлийг удирдах түлхүүр болж байна.

Зах зээлийн эрсдэл

Сангийн удирдаж буй хөрөнгийн үнэлгээ эдийн засаг, улс төр, санхүү болон нийгмийн эрүүл мэндтэй холбоотой (халдварт өвчин, цар тахал гэх мэт) эсхүл зах зээлд өрнөж буй үйл явдлаас шалтгаалан өсөх, буурах зэрэг хэлбэлзэж болно. Дээрх дурьдсан үйл явдлаас шалтгаалсан гэнэтийн өөрчлөлтийг урьдчилан таамаглах, төсөөлөх нь хүнд сорилт байдаг. ХОМК нь нийгэм эдийн засгийн өдөр тутам хувьсан өөрчлөгдөж буй орчинд тохируулан богино хугацаанд хөрөнгө оруулалт ба үйл ажиллагааны оновчтой шийдвэрүүдийг судалгаа шинжилгээнд суурилан ажиллаж байна.

Нэгж эрх эзэмшигчдийн мэдээлэл

2021 оны 8-р сарын 4 хүртэл 6,911 хөрөнгө оруулагчдаас нийт 50 тэр.төг-г татан төвлөрүүлсэн бөгөөд жилийн эцсийн байдлаар хөрөнгө оруулагчийн тоо 7,717 болж 12% өссөн байна.

- Нийт хөрөнгө оруулагчдын 37%-г 30-40 насны иргэд эзэлж байна.
- Нийт хөрөнгө оруулагчдын 48% нь эрэгтэй, 52% нь эмэгтэй байна.
- Нэг хөрөнгө оруулагч дундажаар 7.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ.

График 5: Хөрөнгө оруулагчид
| хүйсээр





График 6: Хөрөнгө оруулагчид
| насаар



Эх сурвалж: ҮЦТХТ, 2021 он

Нэгж эрхийн арилжааны мэдээлэл

Сангийн нэгж эрх нь 2021 оны 8 сарын 20-ны өдөр хоёрдогч зах зээл дээр 1000 төгрөгөөр арилжаалагдаж эхэлсэн бөгөөд 2021 онд 93 өдөр арилжаалагдсан.

Жилийн эцэст өдрийн нэгж эрхийн үнэ 990 байсан нь 1% хувийн бууралттай дүн юм. Тайланд оны турш хамгийн өндөр үнэ 1,194-д хүрсэн бол хамгийн доод үнэ 942 хүрч байв. Харин өдрийн дундаж арилжааны дүн 22.5 сая төгрөг байна.

Цэвэр хөрөнгийн үнэ цэнэ нь хөрөнгө оруулалтын сангийн хувьд нэгж эрхийн үнийг тодорхойлогч гол хүчин зүйл байдаг. Мандал Ирээдүйн Өсөлт ХОС-ийн хувьд Цэвэр хөрөнгийн үнэ цэнэ нь өссөөр байгаа бөгөөд оны эцэст 1022.2 төгрөгөөр хаагдсан.

График 7: Нэгж эрхийн арилжааны мэдээлэл



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

Гэсэн хэдий ч арилжааны 58 өдөр буюу 10 сарын дундаас хойш нэгж эрхийн үнэ нь цэвэр хөрөнгийн үнэ цэнээс багаар арилжаалагдсан байна. Бидний харж буйгаар хөрөнгийн зах зээлээс мөнгө 11, 12 сард гадагшлах урсгал ажиглагдсан. Үүний шалтгаан нь өгөөж болон эрсдэл өндөр хөрөнгө оруулалтын альтернатив бүтээгдэхүүн ихээр гарч ирсэн.

Мөн олон улсын судалгаанаас харахад баярын улирал буюу 11,12 сард хөрөнгө оруулагчдын зан төлөвөөс шалтгаалсан хөрөнгө оруулалтаа худалдах үйл ажиллагаа ажиглагддаг ба манай улсын хувьд мөн адил дүр зураг харагдаж байна.

Гадаадад арилжаалагдаж буй хөрөнгө оруулалтын сангуудын нэгж эрхийн үнэ нь цэвэр хөрөнгийн үнэ цэнээс бага үнээр арилжаалагдах нь ховор тохиолдол юм. Ихэвчлэн сангийн нэгж эрхийн үнэ нь цэвэр хөрөнгийн үнэ цэнээр арилжаалагдах хандлага байдаг.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТҮҮНД ХИЙГДСЭН ХАРААТ БУС АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ДҮГНЭЛТ



Онч Аудит ХХК
15-р давхар Ай Си Си
цамхаг Жамъян гүний
гудамж Сүхбаатар дүүрэг,
1-р хороо Улаанбаатар хот
14240 Монгол Улс

Утас: +976 70100450
976 70120450
Факс: +976 70130450
www.onch.mn

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан ХХК-ийн нэгж эрх эзэмшигчид танаа,

Санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дүгнэлт

Бид Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын Хөрөнгө Оруулалтын Сан ХХК (цаашид "Сан" гэх)-ийн 2021 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан, дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХОС ХХК САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН 2021 ОНЫ 12 САРЫН 31 (МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	Тодруулга	2021
ХӨРӨНГӨ		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5	10,277
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	6	44,841,673
Бодит үнэ цэнийг нь ашиг, алдагдлаар бүртгэдэг санхүүгийн хөрөнгө	7	4,864,033
Хүүгийн авлага		427,008
Хойшлуулсан зардал	8	985,306
Хойшлогдсон татварын хөрөнгө	13.3	45,457
		51,173,754
Нийт Хөрөнгө		51,173,754
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Бусад өглөг		125,955
Орлогын албан татварын өглөг	13.2	46,315
Нийт өр төлбөр		172,270
Эздийн өмч		
Гаргасан нэгж эрх	9	50,000,000
Хуримтлагдсан ашиг		1,001,484
		51,001,484
Нийт өр төлбөр ба эздийн өмч		51,173,754

САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТҮҮНД ХИЙГДСЭН ХАРААТ БУС АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ДҮГНЭЛТ

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХОС ХХК ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН 12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2021 ОН (МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	Тодруулга	2021 оны 5 сарын 18-наас 2021 оны 12 сарын 31
Хүүгийн орлого	11	1,081,229
Бодит үнэ цэнийг нь ашиг, алдагдлаар бүртгэдэг санхүүгийн хөрөнгийн хэрэгжээгүй олз	7	404,784
Нийт орлого		1,486,013
Хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээний зардал	12	(294,905)
Хөрөнгийн биржийн үйлчилгээний зардал	12	(50,000)
Кастодиан үйлчилгээний зардал	12	(27,459)
Мэргэжлийн үйлчилгээний зардал	12	(7,000)
Бусад үйл ажиллагааны зардал	12	(38,885)
Нийт зардал		(418,249)
Татварын өмнөх ашиг		1,067,764
Орлогын албан татварын зардал	13	(66,280)
Тайлант жилийн цэвэр ашиг		1,001,484
Бусад дэлгэрэнгүй орлого		-
Нийт дэлгэрэнгүй орлого		1,001,484

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХОС ХХК ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН 12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2021 ОН (МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	Нэгж эрх	Хуримтлагдсан ашиг	Нийт
2021 оны 5 сарын 18-ны үлдэгдэл	-	-	-
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого	-	1,001,484	1,001,484
Гаргасан нэгж эрх	50,000,000	-	50,000,000
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	50,000,000	1,001,484	51,001,484

САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТҮҮНД ХИЙГДСЭН ХАРААТ БУС АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ДҮГНЭЛТ

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХОС ХХК МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН 12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2021 ОН (МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	Тодруулга	2021 оны 5 сарын 18-наас 2021 оны 12 сарын 31
Тайлант жилийн цэвэр ашиг		1,001,484
Тохируулгууд:		
Хүүгийн орлого	11	(1,081,229)
Бодит үнэ цэнийг нь ашиг, алдагдлаар бүртгэдэг санхүүгийн хөрөнгийн хэрэгжээгүй олз	7	(404,784)
Орлогын татварын зардал	13	66,280
		(418,249)
Ажлын капиталын өөрчлөлт:		
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн өсөлт		(44,841,673)
Бодит үнэ цэнийг нь ашиг, алдагдлаар бүртгэдэг санхүүгийн хөрөнгийн өсөлт		(4,459,249)
Хойшлогдсон зардлын өсөлт		(985,306)
Бусад өглөгийн өсөлт		125,955
		(50,578,522)
Төлсөн орлогын татвар		(65,422)
Хүлээн авсан хүү		654,221
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(49,989,723)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Гаргасан нэгж эрх	9	50,000,000
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		50,000,000
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн өсөлт		10,277
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5	10,277

САНГИЙН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТ

“Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын ХОС”-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт болон 2021 оны зорилго зорилтуудын гүйцэтгэлийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталсан дүгнэлтийг эрхэм хөрөнгө оруулагч та бүхэнд танилцуулж байна.

“Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын ХОС” нь 2021 оны 12 сарын 19-ны өдөр ТУЗ-ийн ээлжит хурлаар сангийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэлэлцсэн баталсан. Хурлаар баталсан Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний үндсэн чиглэл нь системийн нөлөө бүхий банкны IPO-д оролцон улмаар хөрөнгө байршуулалтыг оновчтой хийх, сангийн хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлж хөрөнгө оруулагчдад зорилтот өгөөжийг хуваарилах тухай юм.

Мандал Ирээдүйн Өсөлт сан нь хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөөр үр ашигтай хөрөнгө оруулалтууд хийж 2021 оны 12 сарын 31-ны байдлаар 1.001.5 сая (нэг тэрбум нэг сая таван зуун мянган төгрөг)-ийн ашигтай (татвар төлсний дараа) ажиллаж, цэвэр активын үнэлгээ 51,001.5 сая (тавин нэгэн тэрбум нэг сая таван зуун мянган төгрөг) төгрөгт хүрлээ.

Өнгөрч буй 2021 онд цар тахлын нөлөө бүрэн намжаагүй, зах зээл дэх хүү буурсан, бизнесийн орчинд тодорхой бус давамгайлсан, системийн банкнуудын IPO хойшилсон нэлээдгүй сорилттой жил болж өнгөрлөө. “Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын ХОС”-ийн менежментийн баг эдийн засгийн сорилттой энэ цаг үед тохирсон хөрөнгө оруулалтын стратеги баримтлан, хөрөнгө оруулалтын багцын хөрөнгийг өсгөн, амжилттай ажилласан гэж ТУЗ-аас дүгнэж байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ө. ГАНЗОРИГ

ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Мандал Ассет Менежмент ҮЦК

Алсын хараа:

Хөрөнгө оруулалтын менежментийн хамгийн итгэлтэй мэргэжлийн компани байх

Эрхэм зорилго:

Хөрөнгө оруулагчиддаа урт хугацаанд тогтвортойгоор үнэ цэнэ өгөөжийг хүртээх

Мандал Ассет Менежмент ҮЦК (цаашид “ХОМК гэх) нь 2011 оны 7 дугаар сарын 19-нд байгуулагдсан ба улмаар 2021 оны 3-р сарын 26-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооноос тусгай зөвшөөрөл авснаар хөрөнгө оруулалтын менежмент, зөвлөх үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх болсон.

ХОМК нь одоогоор гурван төрлийн сангаар дамжуулан нийт 125 тэрбум төгрөгийг удирдаж буй Монголын томоохон хөрөнгө удирдлагын компанийн нэг юм. Үүнээс 50 тэрбум төгрөгийг Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС ХХК (цаашид “Сан” гэх)-аар дамжуулан татан төвлөрүүлж, хууль, дүрэм, журамд заасан хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд хөрөнгөө байршуулан ажиллаж байна.

КАСТОДИАНД ХӨРӨНГӨ ХАДГАЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИЛИЙН ТАЙЛАН

ГОЛОМТ БАНКНЫ КАСТОДИАН БАНКНЫ ХЭЛТСИЙН ТАНИЛЦУУЛГА

2013 онд шинэчлэн батлагдсан Үнэт Цаасны Зах Зээлийн Тухай Хууль, шинээр батлагдсан Хөрөнгө Оруулалтын Сангийн Тухай Хуулиар хөрөнгө оруулалтын сан болон түүнд үйлчилгээ үзүүлэгч талуудын үүрэг, харилцааг зохицуулах болсон билээ.

Голомт банк нь 2014 оны 08 сарын 27-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооноос хамгийн анхны кастодиан банкны тусгай зөвшөөрлийг авсан. Үнэт цаасны тухайлсан бүртгэлийн үйл ажиллагааг хавсран эрхлэх нэмэлт тусгай зөвшөөрлийг 2017 оны 12 сарын 15-ны өдөр авснаар хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг бүртгэж хадгалах, төлбөр тооцоог гүйцэтгэхээс гадна нэгж эрхийн тухайлсан бүртгэл хөтлөх, нэгж эрхийн цэвэр үнэлгээ тооцоолох зэрэг цогц үйлчилгээг хөрөнгө оруулалтын менежментийн компаниас хараат бусаар гүйцэтгэн, хөрөнгө оруулагчид болон зохицуулагч байгууллагад сангийн талаар бие даасан мэдээлэл хүргүүлэх боломжтой болсон.

- 2014 • Кастодианы тусгай зөвшөөрлийг хамгийн анх авсан
- 2015 • Үйлчилгээний нээлтийг албан ёсоор хийв
- Японы Nomura ICS системийг нэвтрүүлсэн
- Анхны харилцагчаа бүртгэв
- 2016 • MIT системтэй бүрэн холболт хийв
- Төвлөрсөн хадгаламжийн гишүүн болов
- 2017 • Глобал кастодианы шаардлагыг бүрэн хангаж саб-кастодиан болов
- Үнэт цаасны тухайлсан бүртгэлийн зөвшөөрөл авсан
- 2018 • Олон улсын ISAE 3402 стандартыг хангасан
- 2019 • ICBC хамтын ажиллагааг эхлүүлэв
- Гадаад төлбөр, тооцоо гүйцэтгэх болсон
- 2020 • Клирингийн Ерөнхий Гишүүн болов
- Хамгийн анхны хамтын ХОС-д цогц үйлчилгээ үзүүлж эхэлсэн
- 2021 • Хамгийн том хамтын ХОС-д цогц үйлчилгээ үзүүлж эхэлсэн
- Клирингийн бус 3 гишүүнийг элсүүлж, клирингийн болон төлбөрийн үйлчилгээ үзүүлж эхэлсэн.

2021 оны 06 сарын 16-ны өдөр Голомт банк болон Мандал Ассет Менежмент ҮЦК нь Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, дүрэм, журмын хүрээнд “Хөрөнгө хадгалах, кастодианы үйлчилгээний гэрээ” байгуулснаар Голомт Кастодиан банк нь “Мандал ирээдүйн өсөлт хамтын хаалттай ХОС”-д оруулсан хөрөнгө оруулалтыг бүртгэж хадгалах, үнэт цаас худалдаж авахтай холбоотой төлбөр тооцоог гүйцэтгэх, хүүгийн болон ногдол ашиг цуглуулах, нэгж эрхийн тухайлсан бүртгэл хөтлөх, нэгж эрхийн цэвэр үнэлгээ тооцоолж олон нийтэд мэдээлэх зэрэг цогц үйлчилгээг үзүүлэх болсон.

КАСТОДИАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН

Голомт банкны кастодиан банкны хэлтэс нь Сантай байгуулсан “Хөрөнгө хадгалах, кастодианы үйлчилгээний гэрээ”-ний үндсэн дээр доорх үйл ажиллагааг Санд үзүүлж байна. Үүнд:

ХӨРӨНГӨ ХАДГАЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ

Голомт банкны кастодиан банк нь 2021 оны 12 сарын 31 байдлаар Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС ХХК-ийн 51.1 тэрбум төгрөгийн хөрөнгийг хадгалж байна.

НЭГЖ ЭРХИЙН ТУХАЙЛСАН БҮРТГЭЛ

Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС ХХК нь Монголын Хөрөнгийн Биржээр нэгж эрхээ арилжаалдаг бөгөөд нэгж эрхийн төвлөрсөн бүртгэлийг Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвөөр хийлгэдэг онцлогтой. Нэгэнт нээлттэй зах зээл дээр нэгж эрхээ арилжаалдаг тул Кастодиан банк нь ҮЦТХТ-тэй тусгайлан байгуулсан гэрээний үндсэн дээр нэгж эрхийн шинэ өмчлөгчдийн мэдээллийг өдөр тутам системээр холбогдон авч, тухайлсан бүртгэлийг өдөрт нь гүйцэтгэдэг. Нэгж эрхийн тухайлсан бүртгэлийн эцсийн мэдээллийг Мандал Ассет Менежмент ҮЦК-аас томилогдсон “Мандал ирээдүйн өсөлт хамтын хаалттай ХОС” ХХК-ийн менежерүүдэд тусгайлан олгосон эрхээр өөрийн системээр дамжуулж өдөр тутам мэдээлдэг болно.

НЭГЖ ЭРХИЙН ЦЭВЭР ҮНЭЛГЭЭ

Кастодиан банк нь хөрөнгө оруулалтын сангийн цэвэр хөрөнгийн үнэ цэнийг Хөрөнгө Оруулалтын Сангийн Тухай Хууль болон холбогдох дүрэм, журамд заасны дагуу өдөр бүр тооцоолж, Монголын Хөрөнгийн Биржийн вэбсайтаар дамжуулан олон нийтэд мэдээлж байна.



Мандал Ирээдүйн Өсөлт хамтын ХОС

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, 1-р хороо, Жамьяан-
гүний гудамж, Meru Tower-н 6 давхарт 602 тоот

Утас: (976) 7575 9911

И-мэйл: support@mandalasset.mn

Вэб хуудас: www.mandalasset.mn

